



ГОВЬСУМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1022 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 4/293

Чойр

Цэргийн жинхэнэ албанаас халагдах,
цэрэг татлагын үйл ажиллагаа
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 77 дугаар зүйлийн 77.1, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.13, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10, Зэвсэгт Хүчний Жанжин Штабын даргын 2022 оны н/220 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд цэргийн жинхэнэ алба хаах хугацаа дуусаж бэлтгэлээр халагдан ирж байгаа түрүүч, байлдагч нарыг хүлээн авах ажлыг 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдөр, цэргийн жинхэнэ албанд татах ажлыг 2022 оны 10 дугаар сарын 12-24-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Цэргэг татлагын товчооны төв байрыг аймгийн Биеийн тамир, спортын газрын байранд байрлуулсугай.

3. Цэргийн жинхэнэ албанд татах ажлыг удирдан зохион байгуулах цэрэг татлагын товчоог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Товчооны дарга:

Д. Содном

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Ц. Нацагдорж

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандaa)

Ц. Баярхүү

(Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандaa)

Т. Бат-Эрдэнэ

(Сүмбэр сумын Засаг дарга)

П. Ганчимэг

(Шивээговь сумын Засаг дарга)

Г. Анхбаяр

(Баянтал сумын Засаг дарга)

Ц. Мөнх-Од

(Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга)

Т. Чимэд

Товчооны орлогч дарга:

Гишүүд:

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн бодлого хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Н.Оюунбат

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер, ахмад)

4. Цэрэг татлагын үйл ажиллагаанд шаардагдах **4,035,730** (Дөрвөн сая гучин таван мянга долоон зуун гуч) төгрөгийн төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

5. Холбогдох зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

6. Аймгийн цэрэг татлагын товчоо /Д.Содном/-д даалгах нь :

6.1. Аймгийн цэрэг татлагын товчооны гишүүдийн гүйцэтгэх ажил үүргийг нарийн тооцож, цэрэг татлага, халалтын ажилтай холбогдолтой хууль эрх зүйн баримт бичиг, тухайн ажлыг гүйцэтгэх онцлогийн талаар заавар зөвлөгөө өгч, гүйцэтгэлд хяналт тавих;

6.2. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 441 дүгээр тогтоолоор батлагдсан “Иргэнийг цэргийн жинхэнэ албан” эрүүл мэндээр тэнцүүлэх цэргийн алба хаагчийн эрүүл мэндийг тодорхойлох журам”-ыг баримтлан иргэдийг цэргийн жинхэнэ албан тэнцүүлэн авч өгөгдсөн тоон даалгаврыг биелүүлэх;

6.3. Монгол Улсын Батлан хамгаалах тухай, Цэргийн албаны тухай хуулиудад заасан орон нутгийн төр, захиргааны байгууллагын албан тушаалтан, байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригчид, иргэний хулээх үүрэг хариуцлагын талаар ухуулга сурталчилгааны ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

6.4. Албан хэрэг хөтлөлтийн стандартын шаардлага хангасан маягтыг хөтлөн, ажлын байр болон тээврийн хэрэгслээр хангах;

6.5. Цэргийн жинхэнэ албаны хугацаа дуусаж, бэлтгэлээр халагдан ирж байгаа цэргийн үүрэгтнүүдийг хүлээн авч, ажлын байраар хангах, төрөл бүрийн мэргэжил олгох сургалтад хамруулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг тус тус даалгасугай.

7. Хугацаат цэргийн албанд татагдах тухай “Цэргийн зарлан дуудах мэдэгдэл” аваад цэрэг татлагын байранд тогтоосон хугацаандаа ирээгүй болон хугацаат цэргийн албаны татлагаас удаа дараалан зайлсхийсэн хүмүүст Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авахыг Цэргийн штаб /хурандаа Ц.Нацагдорж/-т зөвшөөрсүгэй.

8. Цэрэг татлагын үед нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулж, “Хугацаат цэргийн албанд татагдах зарлан дуудах мэдэгдэл” аваад тогтоосон хугацаанд, заасан байранд ирээгүй цэргийн үүрэгтнийг цэрэг татлагын товчоонаас өгсөн нэрийн жагсаалтын дагуу тодотгон шалгаж, цэрэг татлагын байранд ирүүлэх ажлыг багийн Засаг дарга, сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа нараар дамжуулан зохион байгуулж хэрэгжүүлэх, хугацаат цэргийн албанд татагдагчдыг тээвэрлэх техникийн бүрэн бүтэн байдалд үзлэг шалгالت хийж, зам, тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Цагдаагийн хэлтсийн дарга, (цагдаагийн хурандаа Ц.Баярхүү)-д хариуцуулсугай.

9.Хугацаат цэргийн албанд татагдагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, нарийн мэргэжлийн эмч сувилагч нарыг томилон удирдлага, мэргэжил арга зүйгээр ханган, шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, хэрэгцээт эм, эмнэлгийн хэрэгслийг бүрдүүлж, үзлэгийг чанартай зохион байгуулах, үзлэгээр эрүүл мэндээр тэнцээгүй иргэдийг эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг улирал тутам аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд энэхүү ажлын үр дүнг харгалзан үзэхийг аймгийн Эрүүл мэндийн газар (Ц.Мөнх-Од)-д даалгасугай.

10.Сум, багийн Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

10.1.Хугацаат цэргийн албанд татагдах залуучуудад “Цэргийн зарлан дуудах мэдэгдэл”-ийг хурдан, шуурхай хүргэж тасалбарыг тухай бүрд нь аймгийн Цэргийн штабт ирүүлж тодотгох, цэрэгт татагдагчдыг заасан байранд тогтоосон цагт бэлэн байлгах;

10.2.Цэргийн алба хаагаагүй 18-25 насны бүртгэл завсардсан залуучуудыг илрүүлэн, нэмэлтээр “Цэргийн зарлан дуудах мэдэгдэл” гардуулж цэрэг татлагад бүрэн хамруулах;

10.3.Цэрэгт татлагын байранд бөөгнөрөл үүсгэхгүй байхаар эмчийн үзлэгийн ширээ хооронд 2 метрийн зйтай, нэг ээлжид эмч нарын тоогоор үзлэгт оруулахаар зохион байгуулах;

10.4.Эмч нарын үзлэгийн бүрэлдэхүүнийг халдварын эрсдэлээс сэргийлж, хамгаалах хэрэгсэл амны хаалт, гар угаах, халдвартгуйжүүлэх уусмал хэрэглэх, нөхцөлийг бүрдүүлэх;

10.5.Өрөө тасалгаа, ариун цэврийн өрөөнд агааржуулалт, ариутгал цэвэрлэгээ, халдвартгуйжүүлэлтийг 1 цаг тутамд хийх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах

10.6.Цар тахал (Ковид-19)-ын халдвараас урьдчилан сэргийлэх, сэжигтэй тохиолдол илэрсэн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулахад бэлэн байхыг тус тус даалгасугай.

11.Цэрэг татлагын ажлыг мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж, үр дүнг 2022 оны 10 дугаар сарын 25-нд илтгэхийг Цэргийн штабын дарга (хурандаа Ц.Нацагдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ



Аймгийн Засаг даргын 2022 оны

22 дүгээр сарын 20-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Хугацаат цэргийн албаны ээлжит татлага, халалтын
ажилд зарцуулах төсөв

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ, төгрөг	Бүгд үнэ, төгрөг	Тайлбар
1	Цэргэг татлагын байранд ажиллах бүрэлдэхүүн болон хугацаат цэргийн албандаа татагдагсдад хоол, цай	20 хүн 5 өдөр, 40 хүн 1 өдөр	20x5x15000= 1500000 40x1x12000= 480000	1,980,000	Нийт 5 хоног ажиллана, 3X-ний ангид ХЦА-нд татагдагсдыг хургэж өгөх замд нэг удаа хооллох
2	Цэргэг татлагын үед ажиллах автомашины шатахууны зардал	2 нэгж автомашин /130 км/	АИ-92-24 л *2480	59,520	УАЗ-452 /18 л/
			LPG- 20кг*1790	35,800	Sonata /15 л/
3	Цэргийн жинхэнэ албандаа татагдагсдыг Зэвсэгт хүчний төв дамжин руу тээвэрлэх автомашины зардал	2 өдөр, 3 нэгж автомашин /700 км/	АИ-92-70 л* 2480	173,600	Stareks /10 л/
			ДТ-126 л*3610	454,860	Caunty/18 л/
			LPG - 105кг *1790	187,950	Sonata /15 л/
4	Цэргэг татлагын комиссоор орж тэнцсэн бие бүрэлдэхүүний гэнэтийн ослын даатгалд хамруулах	40	5000	200,000	Хоногийн багасгах зардал Хоногийн багасгах зардал Хоногийн багасгах зардал
5	Цэргэг татлагын комиссоор орж тэнцсэн бие бүрэлдэхүүний цээжний зураг авах, шээс, цусанд ерөнхий шинжилгээ, хэвллийн хөндийд чанд авиа оношилгоо хийх	40 хүн	20000	800,000	Монгол улсын Засгийн газрын 2019 оны 441 дүгээр тогтоол
6	Сурталчилгааны нугалбар хэвлэх	350 ш	7*16000	112,000	Батлан хамгаалах хууль, тогтоомжийг сурталчилна
7	Printer хор	4 өнгө	8000	32,000	
Бүгд дүн				4,035,730	